

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/92, А/58

Улаанбаатар хот

Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний
үнэлгээ хийх эрх олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Технологи дамжуулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/381, А/274, А-313 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам”-ын 3.1 дэх хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/235, А/200 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн 2024 оны ТТЭ-2024-01 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Трү Ти Ар Си” ХХК (РД:6610188), “Аж үйлдвэрийн паркийн технологи дамжуулах төв” НҮТББ (РД:8091196)-д хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрхийг 3 жилийн хугацаатай тус тус олгосугай.

2. Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журам, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг “Трү Ти Ар Си” ХХК (С.Хандмаа), “Аж үйлдвэрийн паркийн технологи дамжуулах төв” НҮТББ (Б.Артагбат)-д тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД

Ж.ГАНБААТАР